

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/83/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
Залруулсан алдаа	15
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	17
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/74
танай _____-ны № _____-Т

ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ч.ЖАВЗАНПАГМА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ИТХ-ын 2023 оны төсөвт Гадаад томилолтын зардал батлагдаагүй бөгөөд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардлаас 43 хүний зорчих тийзний үнэ 55,240.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,564,780.0	5,686,254.0
35	БАРАА МАТЕРИАЛ	5,564,780.0	5,686,254.0
354	Хангамжийн материал	5,564,780.0	5,686,254.0
35410	Бичиг хэргийн материал	0.0	72,000.0
35420	Аж ахуйн материал	4,166,780.0	3,722,280.0
35440	Түлш, шатах тослох материал	0.0	1,891,974.0
35470	Бусад хангамжийн материал	1,398,000.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	145,186,161.0	101,566,259.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	145,186,161.0	101,566,259.2
392	Биет хөрөнгө	145,121,994.0	101,566,259.2
39203	Авто-тээврийн хэрэгсэл	267,800,000.0	267,800,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-168,521,666.9	-211,648,333.6
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,617,360.0	66,657,090.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-35,214,333.2	-24,281,151.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,792,130.0	11,792,130.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,351,495.9	-8,753,475.8
393	Биет бус хөрөнгө	64,167.0	0.0
39301	Программ хангамж	770,000.0	770,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-705,833.0	-770,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	150,750,941.0	107,252,513.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.1
413	Өглөг	0.0	0.1
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	0.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	150,750,941.0	107,252,513.1
51	Засгийн газрын хувь оролцоо	150,750,941.0	107,252,513.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,110,522.0	211,110,522.0
51101	Өмч: - төрийн	211,110,522.0	211,110,522.0
512	Хуримтлагдсан үр дүн	-65,422,661.0	-107,375,538.9
51210	Өмнөх үеийн үр дүн	-65,422,661.0	-63,877,111.0
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	-43,498,427.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,063,080.0	3,517,530.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	150,750,941.0	107,252,513.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,496,377,500.0	1,252,776,562.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,420,000.0	60,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	12,420,000.0	60,000.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	12,420,000.0	60,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,483,957,500.0	1,252,716,562.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	409,900,000.0	464,206,162.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	409,900,000.0	464,206,162.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,074,057,500.0	788,510,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,074,057,500.0	788,510,400.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,429,526,797.9	1,296,274,989.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,429,526,797.9	1,296,274,989.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	953,015,732.9	853,480,084.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,990,015.0	377,737,855.6
210101	Үндсэн цалин	191,108,211.0	377,737,855.6
210102	Нэмэгдэл	755,804.0	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,000.0	0.0

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,989,950.0	47,132,011.9
210201	Тэтгэврийн даатгал	17,482,862.0	31,606,420.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,851,602.0	3,763,971.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,509,280.0	3,135,021.0
210204	Ажилгүйдлийн даатгал	373,004.0	788,648.7
210205	Эрүүл мэндийн даатгал	3,773,202.0	7,837,951.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,185,500.0	22,153,423.0
210401	Бичиг хэрэг	2,589,430.0	2,624,250.0
210402	Тээвэр, шатахуун	12,359,600.0	18,137,311.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,236,470.0	1,391,862.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,033,160.0	6,034,350.0
210604	Урсгал засвар	7,033,160.0	6,034,350.0
2107	Томилолт, зочны зардал	6,826,500.0	8,966,000.0
210702	Дотоод албан томилолт	6,826,500.0	8,966,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,043,825.0	57,032,522.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	498,079,995.0	53,110,610.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	480,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.0	3,099,075.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,830.0	236,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.0	106,837.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,946,782.9	334,423,921.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,606,750.0	233,804,020.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,120,130.0	42,000,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,219,902.9	58,619,901.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	476,511,065.0	442,794,905.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	409,954,267.0	409,819,900.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	400,000,000.0	400,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,954,267.0	9,819,900.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,556,798.0	32,975,005.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,556,798.0	32,975,005.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	66,850,702.1	-43,498,427.9
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	66,850,702.1	-43,498,427.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,483,957,500.0	1,252,716,562.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,483,957,500.0	1,252,716,562.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	409,900,000.0	464,206,162.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	409,900,000.0	464,206,162.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,074,057,500.0	788,510,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,074,057,500.0	788,510,400.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,414,157,500.0	1,237,716,562.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,414,157,500.0	1,237,716,562.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937,646,435.0	794,921,657.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,533,166.0	377,580,352.4
210101	Үндсэн цалин	131,316,165.0	223,551,730.6
210102	Нэмэгдэл	42,284,357.0	109,604,294.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,061,600.0	13,378,000.0
210104	Урамшуулал	8,871,044.0	28,172,929.3
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	2,873,398.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,446,799.0	47,289,515.0
210201	Тэтгэврийн даатгал	16,886,936.5	31,350,099.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,890,306.8	3,986,506.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,512,625.4	3,189,215.0
210204	Ажилгүйдлийн даатгал	375,914.9	796,696.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,781,015.4	7,966,999.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,051,500.0	24,083,897.0
210401	Бичиг хэрэг	2,217,500.0	2,696,050.0

210402	Тээвэр, шатахуун	12,359,600.0	19,995,985.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,474,400.0	1,391,862.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,879,860.0	6,751,850.0
210604	Урсгал засвар	6,879,860.0	6,751,850.0
2107	Томилолт, зочны зардал	6,826,500.0	8,966,000.0
210702	Дотоод албан томилолт	6,826,500.0	8,966,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	503,739,230.0	54,736,522.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	501,775,400.0	50,814,610.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	480,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.0	3,099,075.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,830.0	236,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.0	106,837.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	187,169,380.0	275,513,520.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,049,250.0	233,513,520.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,120,130.0	42,000,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	476,511,065.0	442,794,905.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	409,954,267.0	409,819,900.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	400,000,000.0	400,000,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,954,267.0	9,819,900.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,556,798.0	32,975,005.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,556,798.0	32,975,005.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	69,800,000.0	15,000,000.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	69,800,000.0	15,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	69,800,000.0	15,000,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	69,800,000.0	15,000,000.0
222001	Тоног төхөөрөмж	69,800,000.0	0.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	15,000,000.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,110,522.0	10,872,900.0	(55,605,349.7)	166,378,072.3
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,110,522.0	10,872,900.0	(55,605,349.7)	166,378,072.3
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(27,504,428.4)	(27,504,428.4)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,110,522.0	5,063,080.0	(65,422,661.0)	150,750,941.0
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,110,522.0	5,063,080.0	(65,422,661.0)	150,750,941.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,545,550.0	1,545,550.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,110,522.0	5,063,080.0	(63,877,111.0)	152,296,491.0
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(1,545,550.0)	-	(1,545,550.0)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(43,498,427.9)	(43,498,427.9)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,110,522.0	3,517,530.0	(107,375,538.9)	107,252,513.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	773,510,400.00	762,771,381.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	773,510,400.00	762,771,381.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	763,510,400.00	752,951,481.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	352,153,400.00	352,153,400.00
210101	Үндсэн цалин	250,353,100.00	210,651,501.75
210102	Нэмэгдэл	91,855,300.00	97,195,570.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,945,000.00	13,260,000.00
210104	Урамшуулал	0.00	28,172,929.32
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	2,873,398.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,019,100.00	42,646,292.00
210201	Тэтгэврийн даатгал	29,933,000.00	28,560,192.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,521,500.00	3,521,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,817,200.00	2,817,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	704,300.00	704,300.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,961,900.00	24,083,897.00
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	2,696,050.00
210402	Тээвэр, шатахуун	20,000,000.00	19,995,985.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	6,800,000.00	6,751,850.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,826,000.00	42,836,522.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,000,000.00	38,914,610.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.00	480,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,000,000.00	3,099,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,000.00	236,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	280,700,000.00	275,513,520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	238,700,000.00	233,513,520.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	9,819,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,000,000.00	15,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	0.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0.00	0.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	788,510,400.00	788,510,400.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	12.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	152,324,209.00	441,970,175.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,324,209.00	441,970,175.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,477,824.00	41,970,175.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	25,426,952.37

210101	Үндсэн цалин	00.00	12,900,228.84
210102	Нэмэгдэл	00.00	12,408,723.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	118,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	4,643,223.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	2,789,907.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	465,006.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	372,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	92,396.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	923,899.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,842,800.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,842,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	910,500.00	00.00
210604	Урсгал засвар	910,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	11,900,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	11,900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23724524.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,724,524.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125846385.00	400,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,846,385.00	400,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	121,000,000.00	400,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,846,385.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	141505646.00	442,899,635.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,505,646.00	442,899,635.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,925,646.00	352,999,635.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,580,000.00	89,900,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн нийтлэг эрх ашгийг дээдэлж, оролцоонд тулгуурлан, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон богино хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулан баталж, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэн, олон улсын стандарт нэвтрүүлэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэн ажилладаг байгууллага юм.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2023 онд ажлын ёс зүйн зөрчилгүй ажилласан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 13 дугаар хуралдааны 10 дугаар тоот тогтоолын дагуу Чанарын удирдлагын тогтолцоо ISO стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн ажилласан байна. Ажлын албаны албан хаагчдад 5S зарчмыг хэрэгжүүлж ажилласан байна.

2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 17 дугаар хуралдааны 16 дугаар тогтоолоор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө 99,4 хувь, Ажлын албаны гүйцэтгэлийн төлөвлөгөө 95,1 хувийн хэрэгжилттэй байсан ба аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Зөвлөл, Ажлын албаны үйл ажиллагаа нь “Бүрэн хэрэгжсэн” байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн "Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам"-ыг шинэчлэн батлах тухай" А/17 тушаал, 1 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг мөрдөн ажиллаж байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод хяналт шалгалтын нэгж нь ажлын албанд Дотоод хяналт шалгалт зохион байгуулах төлөвлөгөөг батлуулан шилэн данс төсөв санхүүгийн ил тод байдал, архив, албан хэрэг хөтлөлт, өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт хамгаалалт, албан хаагчдын цаг ашиглалт, веб хуудас ашиглалтад холбогдох хууль дүрэм журмын хүрээнд удирдамж боловсруулан дотоод хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тайлант онд Аймгийн ИТХ-аас баталсан тогтоол шийдвэрүүдэд хяналт шинжилгээ хийж дүнг хууль зүйн дотоод хэргийн яамд хүргүүлсэн байна. Мөн байгууллагын цахим мэдээллийн ашиглалт баяжилтад хяналт тавьсан байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын 2023 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан цаг ашиглалтын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ачаалал, хийдлийг тодорхойлж удирдлагыг мэдээллээр хангах, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор 2023 оны 3 дугаар сарын 01-ээс 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл албан хаагчдын цаг ашиглалт, бүртгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,498.4 мянган төгрөгөөр буюу 28,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	5,564.8	5,686.3	121.5
Үндсэн хөрөнгө	145,186.2	101,566.3	(43,619.9)
Нийт хөрөнгө	150,750.9	107,252.5	(43,498.4)
Өр төлбөр	-	0.0	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	150,750.9	107,252.5	(43,498.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	150,750.9	107,252.5	(43,498.4)

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 72,000.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 1,891,974.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, аж ахуйн материал 444,500.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,398,000.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд акталсан 25,960.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 15,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 107,253.0 мянган төгрөг болж 43,498.0 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2023 оны төсвийн төсөөллийг 1,360,377.63 мянган төгрөгөөр төсөвлөж саналыг хүргүүлсэн бөгөөд 2023 оны төсөв Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны 13 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор 958,628.4 мянган төгрөгөөр батлагдсан. Энэ нь 401,749.23 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна.

2023 онд батлагдсан төсөвт өөрчлөлт орж Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 04-ны ээлжит бус хуралдааны 02 дугаар тогтоолоор 958,510.5 мянган төгрөгөөр батлагдан, санхүүжилт авсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвийг 958,510.5 мянган төгрөгөөр буюу 117.9 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 777,771.4 мянган төгрөг буюу 98,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 5,287.0 мянган төгрөгөөр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 5,186.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, 10,739.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа-Үндсэн үйл ажиллагааны зардал	578,010.40	572,723.35	5,287.05	99.1%
2	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа-Мэдээлэл, сурталчилгааны зардал	8,700.00	8,621.10	78.9	99.1%
3	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа-Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	6,800.00	6,793.51	6.5	99.9%
4	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	10,000.00	9,819.90	180.1	98.2%
5	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа-Бусад	15,000.00	15,000.00	0.0	100%
6	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	170,000.00	164,813.50	5,186.50	96.9%
	Дүн	788,510.40	777,771.36	10,739.04	98.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлогын хувьд Монгол Улсын цагаатгалын нөхөн олговор 400,000.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн 27 сумын хамтарсан ажлыг зохион байгуулах зардал 11,900.0 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэл цалин 30,999.6 мянган төгрөг нийтдээ 442,889.6 мянган төгрөг орсон байна.

Зардлын хувьд: Цагаатгалын нөхөн олговрын олгох иргэний данс руу 400,000.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг 27 суманд 11,900.0 мянган төгрөг хуваарилсан. Орон нутгийн нэмэгдэл цалин 30,070.2 мянган төгрөг зарцуулж, 929.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	Хөтөлбөр 98,9 %	788,510.40	777,771.36

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 38,587.9 мянган төгрөгийн шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээний зардлыг шууд худалдан авалтаар авахаар, 15,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тендер шалгаруулалтын онцгой журмаар авахаар, нийт 53,587.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Худалдан авалтын гүйцэтгэл 47,543.0 мянган төгрөг байна.

Тоног төхөөрөмжийн зардлыг Сорос компьютер ХХК, Радмм ХХК-аас 15,000.0 мянган төгрөгөөр, даатгалын үйлчилгээний зардлыг Монгол даатгал ХХК-аас 3,077.1 мянган төгрөгөөр, урсгал зардлыг М.Шүрэнхүү, Арвайн бөгөө ХХК-аас 6,751.9 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг МТ Баянзүрх ШТС-аас 19,995.9 мянган төгрөгөө, бичиг хэргийн зардлыг Нар сар энэрэл ХХК, Мөнх Эм Эйс ХХК-аас 2,696.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авсан байна.

Шуудан холбооны зардлыг Монголын цахилгаан холбоо ТӨХК, Монгол шуудан ХХК-аас 1,391.9 мянган төгрөгөөр, Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох төлбөрийн зардлыг Төв аймаг дахь Төрийн газраас 480.0 мянган төгрөгөөр, Тээврийн хэрэгслийн албан татварыг Төв аймгийн Татварын хэлтэст 236.0 мянган төгрөг, Тээврийн хэрэгслийн оношилгооны төлбөрийн зардлыг Төв аймгийн АТҮГ-т 106.8 мянган төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарч худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,496,377.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 22,445.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн

материаллаг байдлын 75 хувиар буюу 16,834.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн ИТХ нь байгууллагад бүртгэлтэй 0001ТӨВ, 0002ТӨА, 0049ТӨҮ улсын дугаарыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу цэнхэр дэвсгэрээр сольсон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд авч хэрэгжүүлсэн өөр арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 169 мэдээллээс хугацаа болоогүй 1 мэдээлэл, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 164 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 20 орлогын, 20 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлэхээс болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 43 шийдвэр оруулахаас орлогын 4 гүйлгээ, зарлагын 3 гүйлгээ хуулийн хугацаа хоцроож, аудитын явцад нөхөн байршуулж мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 192 дугаар албан тоотой ирүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	1,244.5	1	1,244.5	100%
Нийт дүн	1	1,244.5	1	1,244.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 283,700.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 283,700.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний журналаар томилолтын 464.0 мянган төгрөгийн 5 гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүйгээр зардлаар хаасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 178,117.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 105,119.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Энэ шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.2 Албан шаардлага

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын 2023 оны төсөвт Гадаад томилолтын зардал батлагдаагүй бөгөөд 210801(Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж), 210901(Бараа үйлчилгээний бусад зардал)-аас Бүгд найрамдах Солонгос улс руу ИТХ-ын 36 төлөөлөгч, ИТХ-ын ажлын албаны 5 албан тушаалтан, ИТХ-ын зөвлөх 1 нийтдээ 42 хүний зорчих тийзийн үнэ 51,576.8 мянган төгрөг, Бүгд найрамдах Польш улс руу ИТХ-ын нарийн бичгийн даргын зорчих тийзийн үнэ 3,663.2 мянган төгрөг нийт давхардсан тоогоор 43 хүний 55,240.0 мянган төгрөгийг МИАТ ХК, Тотал азиа ХХК, Тапатрип эжэнси ХХК руу тус тус шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.2-т "Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 "Сахилга баттай байх", 4 дүгээр зүйлийн 4.1.9 "Хариуцлагатай байх", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг болон санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" бол албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түлш, шатах тослох материалын тайланд анхан шатны баримт нь огноо байхгүй, баримт үйлдсэн, зөвшөөрсөн, шалгасан хүний гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй болон хоосон баримт хавсаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Ерөнхий нягтлан бодогч нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "эрх ба үүрэг", "нийцсэн зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тавилга эд хогшлын дансанд 2019 оны 7 дугаар сарын 30-нд ашиглалтад хүлээн авсан 849.8 мянган төгрөгийн сейф, шүүгээнд элэгдэл байгуулаагүй ашиглах жил оруулаагүй байна. Энэ нь УСНББОУС -17 Үндсэн хөрөнгийн 66-д "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тавилга эд хогшлын дансанд байгаа 849.8 мянган төгрөгийн сейф, шүүгээнд элэгдэл байгуулах

2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор 16 нэр төрлийн 1,892.0 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Түүхий эд, материал түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ тоолно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "оршин байх", "эрх ба үүрэг", "нийцсэн зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолж хэвших

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	1	464.0			1	464.0	1	464.0	-	-	-	-
Шилэн данс	1	283,236.9	1	283,236.9			1	283,236.9	-	-	-	-
Дүн	2	283,700.9	1	283,236.9	1	464.0	2	283,700.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гадаад томилолтын зардал батлагдаагүй байхад онгоцны тийзийн үнэ шилжүүлсэн	1	55,240.0			1	55,240.0	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгөд элэгдэл байгуулаагүй	1	849.8	-	-	-	-	1	849.8	-	-	-	-
Түлш шатах тослох материалын тайлангийн анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүй.	1	19,617.4	-	-	1	19,617.4			-	-	-	-
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолоогүй	1	1,892.0	-	-	-	-	1	1,892.0	-	-	-	-
Дүн	4	77,599.2	0	0.0	2	74,857.4	2	2,741.8	-	-	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn